



**УЛААНБААТАР ХОТЫН  
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН  
ТУШААЛ**

2019 оны 04 сарын 30 өдөр

Дугаар А/20

Улаанбаатар хот

**Үнэлгээний хороо байгуулах тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан "Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам"-ын 2 дугаар хэсгийн 2.4.1 дэх заалт, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.9.5, 3.1.21 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Дүүргүүдээс гэр хорооллын айл өрхийн нүхэн жорлон, нийтийн эзэмшлийн бохирдол ихтэй талбайн ариутгал, халдваргүйжүүлэлтийг хийлгүүлэхээр ирүүлсэн хүсэлтийн дагуу гэр хорооллын айл өрхийн бие засах газар, нийтийн эзэмшлийн бохирдол ихтэй талбайг ариутгаж, халдваргүйжүүлэх, зуслангийн айл өрхийн нийтийн бие засах газар, нүхэн жорлонг ариутгаж, халдваргүйжүүлэх, төвлөрсөн хогийн цэгүүдэд ариутгал, халдваргүйжүүлэлт хийх ажлын гүйцэтгэгчийг тус тус сонгон шалгаруулах Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнийг хавсралт ёсоор байгуулсугай.

2. Худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахыг Үнэлгээний хороо /Г.Ууганбаяр/-нд үүрэг болгосугай.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР  
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ  
ДАРГА  Т. ГАНТӨМӨР



Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн  
2019 оны 04 сарын 20  
өдрийн 11:00 тушаалын хавсралт



### ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

Дарга	Г.Ууганбаяр	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтсийн дарга
Гишүүд	Т.Оюунтөгс	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Захиргаа, санхүүгийн хэлтсийн Ахлах мэргэжилтэн
	З.Мөнгөнзул	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтсийн мэргэжилтэн
	Ц.Билгүүн	Сүхбаатар дүүргийн 10-р хороо, 7-р хороолол 21-28 тоотод оршин суугч иргэн
Нарийн бичгийн дарга	Б.Мөнхбаяр	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Захиргаа, санхүүгийн хэлтсийн мэргэжилтэн